

ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН БИЕЛЭЛТ

Худалдан авах ажиллагааны газар

2016-01-04

(2015 оны жилийн эцсийн байдлаар)

№	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар: Заалт	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналтад байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай тэмдэглэл/ өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт
A	1	2	3	4	5

Нэг. Улсын Их Хурлын тогтоол:

1	<p>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2011-06-09, Дугаар 32.</p> <p>Заалт 1.1:</p> <p>Бүх салбарыг хамарсан бараа, ажил, үйлчилгээний стандарт, нийтээр дагаж мөрдөх норм, нормативыг шинэчлэн боловсруулан баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах;</p>	Төрийн байгууллага, ХААГ	Стандартыг судалж, мөрдөх арга хэмжээ авах	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газар нь захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тусгагдсан шаардлагыг үндэслэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, бусад холбогдох хууль, тогтоомж, Сангийн яамнаас батлан гаргасан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгүүд, Засгийн газрын 2013 оны 115 дугаар тогтоолоор баталсан журмын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Тухайн захиалагч байгууллага хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээний стандарт, норм, нормативыг тусгасан зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ирүүлдэг.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тухайн төсөл, арга хэмжээнд тусгай зөвшөөрөл шаардах эсэх талаар</p>	Хамаарах заалт биш тул хяналтаас хасуулах саналтай.
---	---	--------------------------	--	---	---

				төсвийн ерөнхийлөн захирагч нараас тодруулга авах хүсэлт явуулсны дагуу 13 ямаас олгож буй тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг ХААГ-т ирүүлсэн. Тэдгээрийг тендер шалгаруулалтын Үнэлгээний хороод тендерийн баримт бичиг боловсруулахдаа анхааран ажиллах талаар зохицуулалт хийж ажиллав. Бараа, ажил, үйлчилгээний стандарт, нийтээр дагаж мөрдөх норм, нормативыг баталж, мөрдүүлэх үүрэг, чиглэл тус байгууллагын эрхлэх асуудалд хамаарахгүй, салбарын яам, агентлагт хамаарна. (Б-100%)	
2	<p>Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, 2015-12-03, Дугаар 108,</p> <p>Заалт 3:</p> <p>Эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох;</p>	Засгийн газар	<p>2016 онд урсгал зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх,</p> <p>Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хэмнэлт бий болгож ажиллах.</p>	<p>Төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор үйлчилгээний 9 гэрээт ажилчныг 2015 оны 1 сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор 39,4 сая төгрөгийн цалингийн зардал гарсан.</p> <p>Тээвэр шатахууны зардлыг хэмнэх үүднээс Засгийн газрын автобаазтай хамтран ажиллаж, автобаазын жолоочийг гэрээт ажилчнаар тус байгууллагаас цалинжуулан ажилласнаар автобаазад тээвэр шатахууны өглөг нэмж үүсгэхгүй байх боломж бүрдүүлэн ажилласан.</p> <p>2016 оны төсвийн урсгал зардлыг хэмнэх боломж нөхцлийг бүрдүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Уг тогтоол шинээр хяналтад авагдаж байгаа тул зохион байгуулалтын арга хэмжээ авч эхлэх бэлтгэл хангах шатанд байна. Өнгөрсөн оны мэдээллийн хувьд хэрэгжилтэд үнэлгээ өгсөн. (ХШ-90%)</p>	
	УИХ-ын 2 тогтоолын 2 заалтын дүн:			Хэрэгжилтийн явц – 95,0 хувь: 100%-1, 90%-1.	

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:					
	-	-	-	-	-

Гурав. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн зөвлөмж:					
	-	-	-	-	-

Дөрөв. Засгийн газрын тогтоол:					
1	<p>Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам батлах тухай 2013-09-21, Дугаар 322</p> <p>Заалт 2:</p> <p>Энэхүү журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэх</p>	<p>Засгийн газрын гишүүд, Засгийн агентлаг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар</p>	<p>Үр дүнд суурилсан явцын үнэлгээ болон үр дүнд суурилсан ХШҮ хийх аргачлалыг боловсруулах, ХШҮ хийх төлөвлөгөө боловсруулан ажиллах, ХШҮ-ний аргачлалын дагуу гүйцэтгэл, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах.</p>	<p>Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн Худалдан авах ажиллагааны газрын чадавхийг бэхжүүлэх дэд төслийн зөвлөх 2014 онд тус байгууллагад ажиллахдаа худалдан авах ажиллагааны газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон дотоод бүтцийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд үнэлгээ өгөх, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хариуцлагын нэгдсэн тогтолцоог төлөвшүүлэх, хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангуулах, эрсдлийн удирдлага, зөвлөгөө мэдээллээр удирдлагыг хангах замаар агентлагийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх талаар зөвлөмж, гарын авлага бэлтгэж гаргасныг үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд хяналт тавихад ашиглаж байна. Мөн 2013 оны 04 сарын 08-ны өдрийн баталсан “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг барьж ажиллаж байна.</p> <p><u>Үр нөлөө:</u> Дотоод хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөө сайжирч, байгууллагын үйл ажиллагааны чанар, үйл ажиллагаанд ахиц гарсан. 2015 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээгээр 122 төрийн байгууллагаас үнэлгээний оноогоор 2-рт, Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн дүнгээр агентлагуудын дундаас 7-р байранд орж, 90-ээс дээш оноогоор дүгнэгдсэн. ҮАГ-аас тус байгууллагын 2014 оны санхүү, төсвийн тайланд аудит хийж, зөрчилгүй санал, дүгнэлт гарсан.</p>	

				(ХШ-70%)	
2	<p>Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай, 2014-01-28, Дугаар 18.</p> <p>Заалт 1:</p> <p>Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу дотоодын аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон давуу эрх олгож ажиллах.</p> <p>Заалт 2:</p> <p>Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаархи мэдээг худалдан авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган Сангийн яаманд тухай бүр хүргүүлж байх.</p>	Төсвийн ерөнхийлөн захирагч нар, ХААГ	Мэдээг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авах	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 онд баталсан “Давуу эрх тооцох аргачлал” зэргийг мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газраас 2015 онд зарлан зохион байгуулсан 170 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 168 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт давуу эрх тооцохоор тусгаж, үнэлгээг хийсэн.</p> <p>Давуу эрх тооцох аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байгаа тул 2007 онд Сангийн сайдын баталсан давуу эрх тооцох аргачал бүхий журмыг шинэчлэн боловсруулахад тус байгууллагаас саналаа тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны улирлын тайланд тусган 4 удаа тусган мэдээлсэн. (ХШ-90%)</p>	
3	<p>Жагсаалт батлах тухай, 2015-02-02, Дугаар 42.</p> <p>Заалт 1; 2, 3:</p> <p>1. Худалдан авах ажиллагааны газраас 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр, Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар</p>	Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, ХААГ	Энэ тогтоолоор баталсан 59 төсөл, арга хэмжээний захиалагч - төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтарсан төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх,	<p>2015 онд ХААГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд нийт 10 төсвийн ерөнхийлөн захирагчтай 2015 оны 02 сард хамтарсан төлөвлөгөө баталсан ба ХААГ-ын Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Шадар сайдын 2015 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 31 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ХААГ-ын 2015 онд зохион байгуулах 59 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шаардлагатай ТЭЗҮ, төсөл, техникийн</p>	<p>2015 онд зохион байгуулах худалдан авах ажиллагаа бүрэн дууссан, Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор ХААГ-т 2016 онд зохион байгуулах худалдан авах</p>

<p>хавсралт ёсоор тус тус баталсугай.</p> <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх.</p> <p>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>		<p>төлөвлөгөөг Шадар сайдаар батлуулах,</p> <p>Захиалагчдаас зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг шаардаж, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх,</p> <p>Тендерийн урилга, зарыг нийтлэх өдөр тутмын сонины сонгон шалгаруулалтыг зохион байгуулах,</p> <p>Үнэлгээний хороодын гишүүдийг санамсаргүй сонголтын хэлбэрээр сонгон баталж, тендер шалгаруулалтыг зохион байгуулах.</p>	<p>тодорхойлолт, ажлын даалгаврыг захиалагчаас ирүүлэх талаар Төсвийн ерөнхийлөн захирагчдад Шадар сайдаас 2 удаа, ХААГ-аас 5 удаа нийт 7 удаа албан бичиг хүргүүлэн худалдан авах ажиллагааны бэлтгэлийг шуурхай хангах арга хэмжээг хэрэгжүүлэв. Мөн тендерийн урилга, зар нийтлэх өдөр тутмын сонины сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан Өнөөдөр, Монголын Үнэн, Ардчилал сонины редацитай гэрээ байгуулан ажиллаж, гадаадын этгээд оролцох тендерийн урилга, зарыг UB post сонинд англи хэл дээр нийтлүүлж, тендер оролцогчдын өрсөлдөх тэгш боломж, мэдээллийн нээлттэй байдлыг бий болгож ажиллав. 2015 онд эдгээр сонинд тендерийн урилга 67, зөвлөх үйлчилгээний тухай зарлал 4, тендерийн урилгын залруулга 11-ийг, гадаадын этгээд оролцох тендерийн урилга 31, зөвлөх үйлчилгээний тухай зар 3, тендерийн урилгын залруулга 3-ыг UBPost сонинд англи хэлээр нийтлүүлж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, ААН-үүдийн өрсөлдөх тэгш боломжийг ханган ажиллав.</p> <p>Энэхүү тогтоолоор, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 182,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 57 төсөл, арга хэмжээ, Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжигдэх 124,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ, нийт 307,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 59 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газарт 2015 онд зохион байгуулахаар баталсан.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дээрх 59 төсөл, арга хэмжээ нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад 117 багц ажил болж задарсан. Тэдгээрээс 13 төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг холбогдох захиалагч, Төсвийн Ерөнхийлөн захирагч нараас (яамдаас) ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион</p>	<p>ажиллагааны жагсаалт, түүнийг хэрэгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө Шадар сайдын 2015 оны 132 дугаар тушаалаар тус тус батлагдсантай холбоотойгоор 2016 оны оны худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж эхэлсэн.</p> <p>Хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
---	--	---	---	---

				<p>байгуулах боломжгүй болсон, мөн захиалагч байгууллагаас шалтгаалан 15 багц ажил зохион байгуулагдаж байх явцдаа хүчингүй болж, нийт 28 багц ажлыг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Нийт зохион байгуулсан 89 багц ажлын 96,6 хувь нь бүрэн хэрэгжиж гэрээ байгуулсан, 3,4 хувь нь хэрэгжих шатанд буюу гэрээ байгуулах мэдэгдлийг шалгарсан компанид хүргүүлсэн явцтай байна.</p> <p><u>Үр дүн:</u> 2015 онд ХААГ-т зохион байгуулах ажлууд дууссан бөгөөд 100 цахим хэлбэрээр зохион байгуулж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг бүрэн хангаж ажилласан. 2016 оны 01 сарын 10-ны өдрийн байдлаар ХААГ-т зохион байгуулсан 50,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл, арга хэмжээний 151 багцад 45,3 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан нь улсын төсөвт 5,5 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан үр дүнтэй байна. (Б-100%)</p>	
4	<p>Монгол Улсын 2015 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай, 2015-03-23, Дугаар 109.</p> <p>Заалт 7:</p> <p>7.1. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд заасан орлогын төлөвлөгөөг баталсан хуваарийн дагуу оны эхнээс жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч, үйл ажиллагаагаа зохион байгуулах;</p> <p>7.2. Урсгал зардлыг хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол болон энэхүү тогтоолд нийцүүлэн баталж, харьяа төсөвт байгууллагуудад мөрдүүлж</p>	Бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч	<p>Орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах,</p> <p>Төсвийн хэмнэлтийн талаар тусгайлан төлөвлөгөөтэй ажиллаж, хэрэгжүүлэх</p>	<p>ХААГ-ын 2015 оны төсвийн хуваарьт Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас олох орлогыг 100,0 сая төгрөгөөр тусгасан. Тайлант хугацаанд 61,9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 61,9 хувийн биелэлттэй гарав.</p> <p>2015 оноос тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, тендерийн баримт бичгийг цахим худалдан авах ажиллагааны систем meps.gov.mn –д нээлттэй байршуулан, сонирхогчид үнэ төлбөргүй таницах боломжоор хангаж, тухайн тендерт оролцогч ААН тендерт оролцохоор бол хураамжийг төлдөг болсон, түүнчлэн “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын 6.2-т “Цахим тендер шалгаруулалтад оролцох ААН-ийн хураамжийн хэмжээ нь хуулийн 22.2 дахь заалтад үндэслэсэн байх бөгөөд 50 000 (тавин мянган) төгрөг байна” гэж заасан зэрэг нь төсвийн орлогын бүрдүүлэлт буурсан дүнтэй гарах үндэслэл болсон. Энэхүү бодит байдлыг судлан үзэж, 2016 оны төсөвт үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын төлөвлөгөөг 30,0 сая төгрөг байхаар тооцоолон</p>	<p>Төсвийн жилийн хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

	ажиллах.			бууруулж, батлуулсан. “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” (2014-05-10, Дугаар 147) Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд урсгал зардлыг хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэв. Зарим тэвчиж болох зардал Гадаад, дотоод томилолтын зардал, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал, даатгалын үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн нийт 42,3 сая төгрөгийн зардал гаргаагүй нь улсын төсөвт хэмнэлт бий болгосон. (Б-100%)	
5	<p>Монгол Улсын 2015 оны төсвийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай, 2015-06-08, Дугаар 230.</p> <p>Заалт 4:</p> <p>Энэ тогтоолын I зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолыг удирдлага болгож ажиллах.</p>	Сангийн сайд Ж.Эрдэнэбат, аймаг, нийслэлийн Засаг дарга болон бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Төлөвлөгөөтэй ажиллаж, хэрэгжилтийг хангах	<p>“Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” (2014-05-10, Дугаар 147) Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд урсгал зардлыг хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэв. Зарим тэвчиж болох зардал Гадаад, дотоод томилолтын зардал, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал, даатгалын үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн нийт 42,3 сая төгрөгийн зардлыг гаргаагүй нь улсын төсөвт хэмнэлт бий болгосон.</p> <p>2015 оны Засгийн газрын тогтоолоор “Үйл ажиллагааны урсгал зардал хэмнэх чиглэлээр бүх шатны төсвийн байгууллагад мөрдөх жишиг горим” батлагдсаны дагуу байгууллагын албан бичиг болон ажил хэрэг, хүний нөөц, өдөр тутмын хийсэн ажлын тайлан, цаг бүртгэл, дотоод ажлыг цахим хэлбэрт шилжүүлсэн, удирдлагын зүгээс дотоод сүлжээгээр дамжуулан цахим хэлбэрээр чиглэл өгч, албан хаагчдын гүйцэтгэлийг хянаж хэвшсэн.</p> <p>Балансад бүртгэлтэй 106,0 сая төгрөгийн Ландкрузер 200 автомашиныг бүртгэлээс хасч, Төрийн өмчийн хорооны шийдвэрээр Хил хамгаалах Ерөнхий газарт шилжүүлсэн нь шатахууны зардал</p>	<p>Тухайн төсвийн жилийн хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

				хэмнэгдэхэд мөн нөлөөлсөн. Орон нутгийн хурал, сургалт зөвлөгөөн, худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалтын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулснаар томилолтын зардлыг 4,3 сая төгрөгөөр хэмнэсэн. Тавилга, эд хогшил, хөрөнгө бэлтгэхгүй байх арга хэмжээг авч ажилласан. (Б-100%)	
6	<p>Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай, 2015-07-07, Дугаар 281.</p> <p>Заалт 1:</p> <p>1. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу төсвийн зарим байгууллагад хийсэн бүтцийн өөрчлөлттэй холбогдон гарсан дараах зардалтай холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, шаардагдах хөрөнгийг 2015 оны улсын төсвийн зохих эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт зөвшөөрсүгэй: /Энэ заалтад ЗГ-ын 2015-8-31-ний өдрийн 350-р тогтоолоор өөрчлөлт орсон/ 1.1. цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах, 1.2. байгууллага нь татан буугдсан, чиг үүрэг нь орон тооны хамт цомхотгогдсоны улмаас ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал; 1.3. бүтцийн өөрчлөлттэй холбогдох шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бүхий комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааны төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал, татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсан байгууллагын архив, эд</p>	Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Холбогдох хууль, журамд заасны дагуу бүтцийн өөрчлөлттэй холбоотой хөрөнгийг зарцуулж, тайлагнах.	<p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолоор тус агентлагийн орон тооны хязгаарт өөрчлөлт орж, Шадар сайдын 2015 оны 01 сарын 07-ны өдрийн 03 дугаар тушаалаар агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор газрын даргын 2015 оны 02, 03 дугаар тушаал гарч, бүтцийн өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн. Тус байгууллага 65 орон тоотой, 2 дэд дарга, бүтцийн 8 нэгжтэйгээр ажиллаж байсан бол уг хөтөлбөрийн дагуу тус байгууллага 55 орон тоотой, 5 бүтцийн нэгжтэй, дэд даргагүйгээр, шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтаар ажиллав. Байгууллагын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй уялдуулан ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулан мөрдүүлэв. Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 9 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн ба тэдгээрт 39,7 сая төгрөгийн тэтгэмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ажил олгогчоос олгох, тэтгэмж урамшууллын зардлаас олгосон. Бүтцийн өөрчлөлттэй холбоотой өөр өөрчлөлт, хөрөнгө зардал гараагүй. Орон тооны цомхотголд орсон албан хаагчдын тэтгэмжид олгосон зардлыг холбогдох тайлан, мэдээнд тусган тайлагнаж, мэдээлсэн. Шилэн дансны мэдээлэлд тусгасан. (Б-100%)</p>	<p>Хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

	<p>хогшлыг нүүлгэн шилжүүлэхэд гарсан бусад зардал.</p> <p>Заалт 2:</p> <p>Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хуульд заасны дагуу тайлагнах.</p>				
7	<p>Жагсаалт батлах тухай, 2015-08-17, Дугаар 336.</p> <p>Заалт 2:</p> <p>Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж, жил бүрийн худалдан авахаар батлуулсан бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр сард багтаан үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх.</p>	Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт	<p>Зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагаанд мөрдөж, тендерийн баримт бичигт тусгах,</p> <p>Төлөвлөгөөний биелэлтийг холбогдох яаманд хүргүүлэх,</p> <p>Тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайлан, мэдээнд тусгах.</p>	<p>Уг тогтоол гарсан 08 сараас хойших хугацаанд 2015 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хүрээнд 3 төсөл, арга хэмжээний 46 багцын тендерийн баримт бичигт тусгаж, дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Холбогдох мэдээг 2016 оны 01 сарын 06-ны өдрийн 1/09 тоот албан бичгээр Аж үйлдвэрийн яаманд хүргүүлэв.</p> <p>2016 онд хэрэгжүүлэх 6,4 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн 1 тендер шалгаруулалтын ажил 2015 оны 11 сард ЭМСЯ-аас эрх шилжиж ирсэн. Энэхүү худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2015 оны 11 сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалаар байгуулж, захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, чанар, стандартын шаардлагыг үндэслэн тендерийн баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, журам зааврын дагуу боловсруулан тендер зарлаад байна. (ХШ-90%)</p>	
8	<p>МУ-ын 2015 оны төсвийн тодотголыг УИХ-д өргөн мэдүүлэн батлуулах хүртэл хугацаанд авах зарим арга хэмжээний тухай, 2015-09-21, Дугаар 377.</p> <p>Заалт 2.1:</p> <p>Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэн батлуулах хүртэл хугацаанд 2015 оны эхний 8 сарын төсвийн</p>	Сангийн сайд Б.Болор, бүх шатны төсвийн захирагч нарт	<p>Тэвчиж болох зардлыг хэмнэх.</p> <p>Төсөвт багтаан байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах.</p>	<p>ХААГ-ын зарцуулагдаагүй цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, гадаад, дотоод томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, сургалт семинарын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад төсвөөс олгох татаас, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардлыг зогсоож хэмнэн, нийт 42,3 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт бий болгосон дүнтэй байна. Зайлшгүй шаардлагатай зардлыг 2015 оны төсөвт багтаан</p>	<p>Хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны</p>

	<p>гүйцэтгэлд үндэслэн дор дурдсан зохицуулалт хийж, 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах:</p> <p>1/ бүх шатны төсвийн байгууллагын зарцуулагдаагүй цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, гадаад, дотоод томилт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, сургалт семинарын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад төсвөөс олгох татаас, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардлыг хэмнэж, зайлшгүй шаардлагатай зарим зардлыг 2015 оны тодотголоор батлагдах төсөвт багтаан санхүүжүүлэх;</p>			санхүүжүүлж ажиллан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангасан. (Б-100%)	байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам"-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.
	<p>Заалт 2.3.</p> <p>2015 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хэмнэгдэх боломжтой нийгмийн халамжийн зарим тэтгэмж, хөнгөлөлт, төр болон ажил олгогчоос олгох бүх төрлийн нэг удаагийн тэтгэмж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад олгох тэтгэлэг, ноос, арьс шир, улаан буудайн урамшууллын зардлыг бууруулах;</p>	Сангийн сайд Б.Болор, бүх шатны төсвийн захирагч нарт	Боломжтой зардлыг бууруулж, хэмнэлт бий болгох	2015 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1,5 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 30,4 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн дүнтэй байна. (Б-100%)	<p>Хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам"-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
9	Жагсаалт батлах тухай, 2015-11-23, Дугаар 455.	Худалдан авах ажиллагааны газрын даргын		Худалдан авах ажиллагааны газрын 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт, Засгийн газрын тогтоолын төслийг Монгол Улсын Шадар сайдын "Санал авах тухай"	

	<p>Заалт 2:</p> <p>Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэх, холбогдох зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуулийн хугацаанд Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэх.</p>	<p>үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Улам-Өрнөхөд,</p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагч нарт.</p>		<p>албан бичгийн хамт бүх Төсвийн Ерөнхийлөн захирагч, Хөгжлийн банк, ОБЕГ, УПЕГ, МТШХХГ, ҮАГ-т хүргүүлсний дүнд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2016 онд ХААГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтыг энэхүү тогтоолоор батлуулав. 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлэх нийт 73,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг тус байгууллагад зохион байгуулахаар баталсан. 2016 онд ХААГ-т зохион байгуулагдах нийт 43 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд хамаарах нийт 11 Төсвийн Ерөнхийлөн захирагч (захиалагч) нарт ХААГ-аас 2016 оны 01 сарын 04-ний өдрийн 1/01 тоот албан бичгийг хүргүүлж, тендер шалгаруулалтад шаардлагатай холбогдох зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуулийн хугацаанд ирүүлж, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх талаар шаардлага тавьж ажилласан.</p> <p>Захиалагчаас зураг төсөв, холбогдох материал нь бэлэн ирсэн ЭМСЯ-ны 1, ХЗЯ-ны 1, БОНХАЖЯ-ны 1, нийт 3 ажлын Үнэлгээний хороо байгуулагдаж, тэдгээрээс 1 ажлын тендер зарласан, нээх болоогүй, 2 ажлын тендерийн баримт бичгийг боловсруулах хүрээнд холбогдох захиалагчтай харьцан материал, тодруулга аван ажиллаж байна. Мөн энэ тогтоолоор 2016 онд төсөвт байгууллагуудын төсвийн урсгал зардлаар худалдан авах бичгийн цаас, принтерийн хор, шатахуун, компьютерийг цахим дэлгүүрээр нийлүүлнэ. Уг барааны нийлүүлэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, Ерөнхий гэрээ байгуулах ажлыг ХААГ-т зохион байгуулах бэлтгэл хангах хүрээнд барааны катологи бий болгох, цахим системд тохируулга</p>
--	---	--	--	--

			хийх ажлууд хийгдэж байна. (ХШ-10%)	
	9 тогтоолын 10 заалтын дүн:		Хэрэгжилтийн явц – 86,0 хувь: 100%-6, 90%-2, 70%-1, 10 % буюу эхэлж байгаа 1 заалт.	

Тав. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл:

1	<p>Цахим худалдан авах ажиллагааны системийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах тухай, 2014-01-11, Дугаар 02</p> <p>Заалт XXII.1:</p> <p>Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим дэлгүүр ажиллуулах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн программ хангамж, техникийн шийдэл, нөхцлийг ашиглан ЦХАА-ны системийг мэдээлэл солилцох төвлөрсөн сүлжээгээр дамжуулан УБЕГ, ШШГЕГ, НДЕГ-ын мэдээллийн системтэй холбох ажлыг зохион байгуулах</p>	<p>МТШХХГ, ХААГ, УБЕГ, ШШГЕГ, НДЕГ-ын дарга нар</p>	<p>Мэдээлэл солилцох төвлөрсөн сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцох байгууллагуудтай уулзалт зохион байгуулах,</p> <p>хамтын ажиллагааны гэрээ байгуулан хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.</p>	<p>“Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” төслийн хүрээнд цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг ашиглалтад оруулахаар зорин ажилласны дүнд шинэ системийн технологийн ажлууд дуусч ашиглалтанд хүлээн авах бэлтгэл хийгдэж байна. “Мэдээлэл солилцоо” дэд системийг УБЕГ-ын систем, Сангийн яамны “Санхүүгийн тайлангийн е-баланс” системүүдтэй холбосон. Татварын Ерөнхий газраас “Татварын лавлагаа авах тухай”, “Автомашин лавлагааг авах тухай” гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүлээн авч, гэрээний төслийг шинэчлэн боловсруулж, ТЕГ-т хүргүүлэв. Худалдан авах ажиллагааны “суурь мэдлэг олгох” сургалтад хамрагдсан оролцогчид шаардлагатай мэдлэг эзэмшсэн болохыг гэрчилсэн гэрчилгээг Төрийн үйлчилгээний цахим машинаар дамжуулан олгох асуудал шийдвэрлэгдэж, 2016 оноос хэрэгжихээр болов. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу тендер оролцогч хуулийн этгээдийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, төлбөр болон тухайн хуулийн этгээдийн нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа даатгуулагчийн талаарх мэдээлэл, лавлагааг цахим хэлбэрээр солилцох саналыг “Мэдээлэл солилцох гэрээ”-ний төслийн хамт ХААГ-ын 2015 оны 02 сарын 06-ны өдрийн 1/65 дугаартай албан бичгээр НДЕГ-т хүргүүлсэн боловч ийм мэдээлэл солилцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай программ хангамжийг шийдвэрлэж дууссаны дараа дээрх гэрээг байгуулах тухайгаа НДЕГ-аас манайд мэдэгдсэн. Энэ шалтгааны улмаас НДЕГ-тай мэдээлэл солилцоо онлайн хэлбэрээр хийгдэх ажил ХААГ-аас үл шалтгаалах байдлаар хүлээгдэж байна.</p>	
---	--	---	---	---	--

				(ХШ-70%)	
2	<p>Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг батлах тухай 2014-12-15, Дугаар 63</p> <p>Заалт: IY.1.</p> <p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл оруулахтай холбоотой сургалтыг эрхлэх асуудлынхаа хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудад 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулах</p>	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт	<p>Холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад холбогдох мэргэжилтнийг хамруулах,</p> <p>Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь ил тод мэдээлж ажиллах.</p>	<p>Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, www.shilendans.gov.mn сайтад хэрхэн ажиллах талаарх Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан сургалтад 2014 оны 12 сард нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Сангийн яамнаас зохион байгуулсан шилэн дансны хуулийн сургалтанд байгууллагын Ахлах нягтлан бодогч хамрагдсан. Хуулийн хэрэгжилтийг хангах мэдээлэл, арга зүйг авч ажиллав. 2015 онд Шилэн дансны тухай хуулиар байгууллагууд нийт 37 төрлийн мэдээллийг жил, улирал, сар, 7 хоног, тухай бүрд нь Шилэн дансны системд байршуулахаар заасан бөгөөд 20 төрлийн 46 тайлан, 26 баримт, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн. 2015 онд хөрөнгө оруулалтын ажил тус байгууллагын төсөвт тусгагдаагүй учир холбогдох мэдээлэл мэдээлэгдэх шаардлагагүй байна.</p> <p>Үндэсний аудитын газраас Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийж, өгсөн зөвлөгөө, зөвлөмжийн дагуу “Худалдан авах ажиллагааны газрын шилэн дансны мэдээлэл хөтлөх журам”-ыг 2015 оны Б/25 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.</p> <p>Шилэн дансны мэдээллийн самбарыг “Нэг цэгийн үйлчилгээ”-ний танхимд шинээр байрлуулан иргэд, олон нийтийн зүгээс мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжоор хангаж, мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэн мэдээлж байна.</p> <p>Шилэн дансны хэрэгжилтийн тайланг улирал бүр Сангийн яам, ШСАА, ҮАГ-т тус тус хүргүүлж тайлагнасан. Шилэн дансны хэрэгжилтийн явцыг дараах үзлэг, шалгалтаар шалгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг, 2. Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, 	<p>Хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул 2014 оны жилийн эцсийн тайлангаар цаашид хяналтаас хасах саналтай гэж өмнө санал өгсөн.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

				<p>3. ҮАГ-аас байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны явцад хийсэн шалгалт, 4. Байгууллагын дотоод аудитын шалгалт. Дээрх үзлэг, шалгалт, үнэлгээгээр байгууллагын шилэн дансны мэдээллийн ил тод байдлын талаар зөрчил, доголдол илрээгүй. <u>Үр нөлөө:</u> Шилэн данс цэсэнд мэдээлэл оруулах ажилтны ажил үүрэг тодорхой болж, мэдээллийг цаг хугацаанд нь оруулан мэдээлж хэвшсэн. Ингэснээр Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үнэлгээгээр тус байгууллагын санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын асуудлаарх ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн үнэлгээ бүрэн оноогоо авч үнэлэгдсэн. (Б-100%)</p>	
3	<p>Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тухай, 2015-01-07, Дугаар 01</p> <p>Заалт: XII.4.1.</p> <p>Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл боловсруулахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийн саналыг авч, шаардлагатай бол саналыг тусгах арга хэмжээ авах,</p>	<p>Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт</p>	<p>Эрх зүйн үндэслэлийг судлах, Журам, дүрэм боловсруулан батлахдаа, холбогдох албан хаагчдын саналыг авч тусгах.</p>	<p>Худалдан авах ажиллагааны газрын хэмжээнд гарч буй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй бүтцийн нэгжүүд, алба хаагчдын саналыг урьдчилан авч хэвшээд байна. Худалдан авах ажиллагааны талаар Сангийн яамаар батлуулах нийтлэг хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн саналыг бичгээр авч шийдвэрийн төсөлд тусгаж байна.”Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийн ажиллах журам”-ын төслийг 31 нэгжид хүргүүлэн Архангай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймаг, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албад (10 аймаг, 3 дүүрэг)-аас ирүүлсэн саналыг нэгтгэн журмын төсөлд тусгаж, 2015 оны 03 сарын 24-ний өдрийн 1/183 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Журам Сангийн яамнаас эцэслэн гарна. (Б-100%)</p>	<p>Хэвшиж тогтмолжсон ажил тул хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
	<p>Заалт: XII.4.2:</p> <p>Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын</p>	<p>Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн</p>	<p>Эрх зүйн үндэслэлийг судлах, Холбогдох журам, дүрмийн хэрэгжилтэд</p>	<p>Засгийн газрын 2013 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам, Сангийн сайдын тушаалаар батлагдсан Тендерийн үнэлгээний заавар, Төрийн болон орон</p>	<p>Хэвшиж тогтмолжсон ажил тул хяналтаас хасуулах саналтай</p>

	хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцож байх,	газрын агентлагийн дарга нарт	хяналт тавьж, мониторинг, үнэлгээ хийх.	нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам, Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам зэрэг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын санд бүртгэлтэй шийдвэрүүдийн хэрэгжилтийг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол мөрдөн ажиллаж байгаа бөгөөд биелэлтийг хагас, бүтэн жилээр Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж хэвшээд байна. Ингэснээр байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд дурдсан журмын хэрэгжилтийг хангахад тавьж байгаа хяналт сайжирч байна. (Б-100%)	байна. Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.
	Заалт: XII.4.3: Шинээр гарсан хууль тогтоомжид нийцүүлэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж байх,	Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Эрх зүйн үндэслэлийг судлах, Тухайн бүр хэрэгжүүлэх.	Байгууллагын дотоодод батлан хэрэгжүүлж байгаа дүрэм, журмыг тухай бүр хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна. Тухайлбал, Шилэн дансны тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль гарсантай холбогдуулан 2015 онд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн, ХААГ-ыг шилэн дансны мэдээлэл хөтлөх журмыг шинээр тус тус боловсруулан баталж, “Албан хэрэг хөтлөлт, архивын ажлын журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд нийт 3 удаа хүргүүлсэн. Тайлант хугацаанд, худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Шадар сайдын ажлын алба болон Сангийн яаманд хүргүүлэв. (Б-100%)	
	Заалт: XII.4.4:	Засгийн газрын	Эрх зүйн үндэслэлийг судлах,	Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон	Хэвшиж тогтмолжсон ажил тул хяналтаас

	Хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахгүй байх.	гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Мөрдөж ажиллах.	шийдвэрийг боловсронгуй болгох” уулзалт, сургалтад Хууль, хяналтын хэлтсийн мэргэжилтнийг оролцуулан, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд анхааран ажиллав. Худалдан авах ажиллагаатай холбоотой захиргааны нийтлэг хэм хэмжээг тогтоосон эрх зүйн акт батлан гаргах эрх, үүрэг ХААГ-т байдаггүй болно. Ийм шийдвэр гараагүй. (Б-100%)	хасуулах саналтай байна. Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.
4	Хуулийн төслийн тухай, 2015-01-09, Дугаар 04. Заалт 1.2: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хянан боловсруулж, 2015 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд хуралдаанд оруулах.	Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт	Хуулийн төсөлд холбогдох албан хаагчид, орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжээс санал авч тусгах, Хуулийн төслийг санал авахаар байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх, ШСАА-нд хүргүүлэх,	ХААГ-аас хуулийн шинэчилсэн төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтээс болон хэрэглэгчдээс авсан саналыг тусган боловсруулж, тухайн үеийн Шадар сайдын Ажлын албанд хүргүүлсэн. Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 08 сарын 03-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ШСАА-ны Ахлах зөвлөх, Сангийн яам, тус байгууллагын холбогдох төлөөлөл оролцсон бөгөөд Ажлын хэсэг хуулийн төслийн асуудлаар ШСАА-нд хуралдсан. Олон улсын судалгааны баг ажиллаж холбогдох судалгаа хийсний дараа хуулийн төслийг боловсруулах асуудлыг 2016 оны 5 сар хүртэл хойшлуулахаар төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэрлэсэн. (ХШ-70%)	Шадар сайдын нэр дээр гарсан шийдвэр тул хэрэгжилтийг ШСАА хариуцна. ШСАА-нд хэрэгжилтийн мэдээллийг тусад нь явуулсан.
5	Жагсаалт батлах тухай, 2015-02-02, Дугаар 7. Заалт ХХҮ.2: Худалдан авах ажиллагааны газраас 2015 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад заасан арга	Шадар сайд, ХААГ	Засгийн газарт мэдээлэл бэлтгэж танилцуулах	ХААГ-т худалдан авах ажиллагааг нь зохион байгуулахаар 2015 онд хэрэгжүүлэх нийт 307,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 59 төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2015 оны 02 сарын 02-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан. Эдгээр 59 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад зарим төсөл, арга хэмжээ багц ажил болон	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Худалдан авах ажиллагааны газарт 2015 онд зохион байгуулах худалдан авах ажиллагаа бүрэн дууссан, Засгийн

<p>хэмжээ, төслийн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг 14 хоног тутам Засгийн газарт танилцуулж байх</p>			<p>задарснаар 117 багц ажлын худалдан авах ажиллагааг 2015 онд ХААГ-т зохион байгуулах шуурхай арга хэмжээ авч ажилласан. Засгийн газрын 2015 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах хүрээнд захиалагчаас шаардлагатай зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг тус байгууллагад яаралтай ирүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжоор хангах талаар 10 Төсвийн ерөнхийлөн захирагчид Шадар сайдаас 2 удаа, ХААГ-аас 5 удаа албан бичиг хүргүүлсэн. Дээр дурдсан, шаардлагатай материалыг ирүүлээгүй, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах ажлыг удаашруулж байгаа Төсвийн ерөнхийлөн захирагч нарыг Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд мэдээлэх мэдээлэлд дурдан ЗГХЭГ-аас үүрэг даалгавар өгүүлэн ажилласан. Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” сар бүрийн цахим хуралд мэдээлэх худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг нийт 5 удаа бэлтгэж, ЗГХЭГ-ийн ХШҮДАГ азарт хүргүүлсэн.</p> <p><u>Үр нөлөө:</u> Уг тогтоолоор батлагдсан ХААГ-т худалдан авах ажиллагааг зохион байгуулах 59 төсөл, арга хэмжээний 117 багцаас 13 төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг холбогдох захиалагч, Төсвийн Ерөнхийлөн захирагч нараас (яамдаас) ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй болсон, мөн захиалагч байгууллагаас шалтгаалан 15 багц ажил зохион байгуулагдаж байх явцдаа хүчингүй болж, нийт 28 багц ажлыг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Нийт зохион байгуулсан 89 багц ажлын 96,6 хувь нь бүрэн хэрэгжиж гэрээ байгуулсан, 3,4 хувь нь хэрэгжих шатанд буюу гэрээ байгуулах мэдэгдлийг шалгарсан компанид хүргүүлсэн явцтай байна. (Б-100%)</p>	<p>газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор ХААГ-т 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт, түүнийг хэрэгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө Шадар сайдын 2015 оны 132 дугаар тушаалаар тус тус батлагдсантай холбоотойгоор 2016 оны оны худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж эхэлсэн тул хяналтаас хасах саналтай.</p>
---	--	--	---	--

6	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай, 2015-03-12, Дугаар 13.</p> <p>Заалт XII.2:</p> <p>2.1.1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тайланг улирал тутам гаргаж, Сангийн яаманд хүргүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудсандаа тогтоосон хугацаанд байршуулж байх;</p> <p>2.1.2. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу харьяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.</p>	<p>Төсвийн ерөнхийлөн захирагч,</p> <p>Төсвийн шууд захирагч</p>	<p>Шилэн дансны мэдээллийг ил тод болгох,</p> <p>Холбогдох журмыг батлан хэрэгжүүлэх,</p> <p>Мэдээлэл, арга зүйгээр хангагдах арга хэмжээг авах,</p>	<p>2015 оны 01 сарын 01-ээс эхлэн хэрэгжиж эхэлсэн “Шилэн дансны тухай хууль”-д зааснаар “Шилэн данс” нь бие даасан цэстэй байх шаардлагын дагуу мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллан холбогдох хууль, журамд заасан мэдээллийг байгууллагын цахим хуудас www.e-tender.mn болон Засгийн газрын www.shilendans.gov.mn мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор мэдээлж, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулан мэдээлэв. Мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол шинэчилж хэвшсэн. Шилэн дансны тухай хуулиар байгууллагууд нийт 37 төрлийн мэдээллийг жил, улирал, сар, 7 хоног, тухай бүрд нь Шилэн дансны системд байршуулахаар заасан бөгөөд 23 мэдээллийг уг системд мэдээлсэн. 2015 онд хөрөнгө оруулалтын ажил тус байгууллагын төсөвт тусгагдаагүй учир холбогдох 14 мэдээлэл мэдээлэгдэх шаардлага үүсээгүй. Үндэсний аудитын газраас Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийж, өгсөн зөвлөгөө, зөвлөмжийн дагуу “Худалдан авах ажиллагааны газрын шилэн дансны мэдээлэл хөтлөх журам”-ыг 2015 оны Б/25 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. Шилэн дансны мэдээллийн самбарыг “Нэг цэгийн үйлчилгээ”-ний танхимд шинээр байрлуулан иргэд, олон нийтийн зүгээс мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжоор хангаж, мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэн мэдээлж хэвшив. Шилэн дансны хэрэгжилтийн тайланг улирал бүр Сангийн яам, ШСАА, ҮАГ-т тус тус хүргүүлж тайлагнасан. Шилэн дансны хэрэгжилтийн явцыг дараах үзлэг, шалгалтаар шалгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг, 2. Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, 3. ҮАГ-аас байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны явцад хийсэн шалгалт, 	<p>Хэвшиж тогтмолжсон ажил тул хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
---	---	--	--	---	---

				4. Байгууллагын дотоод аудитын шалгалт. Дээрх үзлэг, шалгалт, үнэлгээгээр байгууллагын шилэн дансны мэдээллийн ил тод байдлын талаар зөрчил, доголдол илрээгүй. (Б-100%)	
7	<p>Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2014 оны жилийн эцсийн дүнгийн тухай, 2015-03-30, Дугаар 18.</p> <p>Заалт XXIII.3:</p> <p>3.1. Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар, сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөтэй, шуурхай зохион байгуулах;</p> <p>3.2. Биелэлтийг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д байршуулах, хэрэгжилтийг бодитой тайлагнах, үнэлэх;</p> <p>3.3. 2014 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжсэн заалтуудыг хяналтаас хасуулах;</p> <p>3.4. хуульд заасан дүрэм, журмуудыг батлан мөрдүүлэх.</p>	Сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар	<p>Заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах,</p> <p>Хяналтад авсан шийдвэр, заалтуудын хэрэгжилтийг хангах,</p> <p>Хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийж, биелэлтийг тогтоосон хугацаанд мэдээлэх,</p> <p>Хэрэгжилтийг холбогдох цахим хуудсуудад байршуулан мэдээлэх.</p>	<p>Тайлант хугацаанд, УИХ, Засгийн газрын нийт 28 шийдвэрийн 38 заалтын хэрэгжилтийг 2014 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, ШСАА, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т хүргүүлсэн ба холбогдох эрх зүйн актын биелэлт 96,1 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн. Хэрэгжилт нь тогтмолжсон, цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдсан, хэрэгжиж хугацаа дууссан УИХ, Засгийн газрын нийт 12 шийдвэрийн 16 заалтыг тогтмол мэдээлж байх хяналтаас хасах саналыг боловсруулж, Засгийн газарт уламжлуулахаар 2015 оын 02 сарын 17-ны өдрийн 1/94 тоот албан бичгээр (уламжлах төслийн хамт) ШСАА-нд хүргүүлсэн. 2014 оны жилийн эцсийн энэхүү дүн, мэдээг байгууллагын удирдах ажилтны шуурхай хуралд танилцуулан мэдээлж, хэрэгжилт нь удааширч байгаа заалтыг шуурхай хэрэгжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтаар хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Дүн, мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн.</p> <p>Мөн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем www.unelgee.gov.mn-д тогтоол, шийдвэрийн 2014 оны болон 2015 оны эхний хагас жилийн биелэлтийг заалт бүрээр оруулж, баталгаажуулалт хийн Засгийн газрын үнэлгээнд 2 удаа хамруулав.</p> <p>2015 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн шинээр батлагдан ирж байгаа дээд шатны байгууллагын 17 шийдвэрийг бүртгэж, хяналтад авсан. 2015 оны эхний хагас жилийн дүнгээр нийт 5 төрлийн 20 шийдвэрийн холбогдох 29 заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан ба эдгээрийн хэрэгжилтийн явц 92,8 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнагдсан. 2015 оны жилийн эцсийн дүнгээр бүртгэл хяналтад авч хэрэгжүүлж байгаа нийт 3 төрлийн 23 эрх зүйн акт (тогтоол, шийдвэр)-ын</p>	<p>Тайлант хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам"-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

				<p>биелэлтийн дүн 92,4 хувийн гүйцэтгэлтэй байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хамаарах худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд мэдээлэхээр 5 удаа мэдээлэл бэлтгэж, ЗГХЭГ-ын ХШДАГ-т хүргүүлэв. (Б-100%)</p>	
8	<p>2015-04-27, Дугаар 23.</p> <p>“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 116 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авах:</p> <p>Заалт: 2.1.</p> <p>Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэмэлт хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг тухайн төсөл, арга хэмжээний тендерт өмнө нь шалгаран ажиллаж байгаа үндсэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах замаар үргэлжлүүлэн дуусгах;</p>	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт		<p>2015 онд ХААГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагаа дууссан. Тендер шалгаруултыг зохион байгуулж, шалгарсан ААН-тэй гэрээ байгуулах зөвлөмжийг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч (захиалагч)-д хүргүүлснээр ХААГ-ын эрхлэх асуудал дуусгавар болдог тул уг тогтоолын заалтаар өгсөн үүрэг чиглэл ХААГ-т хамаарах асуудал биш. Хэрэгжилтийг биелснээр тооцов. (Б-100%)</p>	Хамаарах асуудал биш тул хяналтаас хасуулах саналтай.
	<p>Заалт: 2.2.</p> <p>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, хэрэгжилтийн явцад</p>	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт		<p>Төсвийн ерөнхийлөн захирагч (захиалагч) тендерт шалгарсан компанитай гэрээ хийж, уг төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлдэг тул захиалагчийн хяналтын чиг үүрэгт хамаарах асуудал. ХААГ-ын чиг үүрэгт</p>	Хамаарах асуудал биш тул хяналтаас хасуулах

	байнгын хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлийг гаргуулан хянан баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах.			хамаарахгүй. Хэрэгжилтийг биелснээр тооцов. (Б-100%)	саналтай.
9	<p>Үндэсний хөтөлбөрүүдийн 2014 оны хэрэгжилтийн нэгдсэн дүнгийн тухай, 2015-06-09, Дугаар 39.</p> <p>Заалт ХХХII.1:</p> <p>Эрхэлсэн асуудлын хүрээнд зорилго, зорилт нь давхардаж байгаа хөтөлбөрүүдийг нэгтгэж, 2015 онд хэрэгжиж дуусах хөтөлбөрийн биелэлтэд үнэлгээ өгч, хэрэгжилт нь удааширсан буюу тасарсан хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар тодорхой санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх.</p>	Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт	<p>Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх,</p> <p>Хөтөлбөрүүдийг хэрэгжилтийг тооцож, мэдээлэх.</p>	<p>2013-2015 онд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтийг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нэгтгэн боловсруулж, тайланг ШСАА-нд хүргүүлсэн. Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа 4 үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг тус байгууллагад хэрэгжүүлж байгаа бөгөөд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 1 төсөл 2014 онд хэрэгжиж дууссан. Нийт 5 хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн дундаж хувь 97,3 хувийн гүйцэтгэлтэйгээр мэдээлэгдсэн.</p> <p>ХААГ-ын хяналтад аван хэрэгжүүлж байгаа нийт 4 үндэсний хөтөлбөрийн 1 хөтөлбөр нь тус байгууллагын эрхлэх асуудалтай шууд холбоотой, 3 хөтөлбөрийн хэрэгжилтэд тус байгууллагын оролцоог хангаж, дэмжлэг үзүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2016 онд дуусна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ХААГ-ын чиг үүрэгт хамаарах 3 зорилтын хэрэгжилт 100 хувьтай, хэрэгжиж тогтмолжсон дүнтэй байна. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь Сангийн яам хариуцан Засгийн газрын хуралдаанд оруулах чиг үүрэгтэй. (Б-100%)</p>	<p>Тайлант хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам"-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
10	<p>2015-07-20, Дугаар 43.</p> <p>Заалт: ХХҮ.1.</p> <p>2015 оны эхний хагас жилийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дүнтэй холбогдуулан Монгол Улсын хууль</p>	Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Тогтоол, шийдвэрийн биелэлтийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, Тухайн заалтын хэрэгжилтийг хариуцан ажиллах хэлтэс, албан	2015 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн шинээр батлагдан ирж байгаа дээд шатны байгууллагын 17 шийдвэрийг бүртгэж, хяналтад авсан. 2015 оны эхний хагас жилийн дүнгээр нийт 5 төрлийн 20 шийдвэрийн холбогдох 29 заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан ба эдгээрийн хэрэгжилтийн явц 92,8 хувийн гүйцэтгэлтэйгээр	<p>Тайлант хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322</p>

	тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч байгаа заалтын биелэлтийг эрчимжүүлж ажиллах.		тушаалтныг тодорхой болгох, Дээд шатны байгууллагад хэрэгжилтийг дүгнэж мэдээлэх.	тайлагнагдсан. 2015 оны жилийн эцсийн дүнгээр бүртгэл хяналтад авч хэрэгжүүлж байгаа нийт 3 төрлийн 23 эрх зүйн акт (тогтоол, шийдвэр)-ын биелэлтийн дүн 92,4 хувийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем www.unelgee.gov.mn -д тогтоол, шийдвэрийн 2014 оны болон 2015 оны эхний хагас жилийн биелэлтийг заалт бүрээр оруулж, баталгаажуулалт хийн Засгийн газрын үнэлгээнд 2 удаа хамруулав. (Б-100%)	дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам"-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.
11	<p>МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 2015 оны 09 сарын 5-6-ны өдрүүдэд орон нутагт ажилласан тухай, 2015-09-14, Дугаар 51.</p> <p>Заалт ХҮ.2:</p> <p>Нутгийн удирдлагын байгууллага, ААН-ийн зүгээс зарим тулгамдсан асуудлаар тавьсан саналыг шийдвэрлэх талаар төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, Засгийн газрын ХЭГ-т тайлагнах.</p>	Засгийн газрын гишүүд	Уг төлөвлөгөөнд тусгагдсан хамаарах 1 заалтын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах.	<p>ХААГ-ын 2015 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "ХҮ1.1.2.3 "Хүүхдийн эмнэлгийн их засвар /Орхон, Баян-Өндөр/" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр зохион байгуулах тухай Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр батлан ирүүлсэн ажлын даалгавар, хүсэлтийн дагуу тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.10-д заасны дагуу түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрүүдэд тус бүр 2 удаа нээлттэй тендер шалгаруулалт зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй учир уг хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3-т заасны дагуу өмнөх нээлттэй тендер шалгаруулалтад оролцсон компаниудад шууд гэрээ байгуулах саналын урилга хүргүүлсэн. Мөн шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй. Эрүүл мэнд, спортын яам 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 2/4483 дугаар албан бичгээр уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар сонгон шалгаруулах хүсэлтийг манайд дахин ирүүлсний дагуу гэрээ шууд байгуулах саналын урилгыг олон нийтэд нээлттэй</p>	<p>Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам"-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

				мэдээлэхэд нийт 6 компани оролцох хүсэлт ирүүлсэн. Тэдгээрээс “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн “Цонбон тоосго” ХХК-тай 3,8 тэрбум төгрөгийн гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлж, ЭМСЯ-аас 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулж, гэрээний хувийг тус байгууллагад ирүүлсэн. (Б-100%)	
12	<p>2015-10-12, Дугаар 55.</p> <p>Заалт XXI.1.3:</p> <p>Монгол Улсын 2016 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж байгаа болон Засгийн газар төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан албан ёсны айлчлал, чухал шаардлагатай хөрөнгө оруулалтын уулзалтаас бусад арга хэмжээнд оролцохгүй байх.</p>	Засгийн газрын гишүүд	<p>Тэмдэглэлээр өгсөн үүргийг чиглэл болгож ажиллах,</p> <p>Гадаад томилолтод хөрөнгө зарцуулахгүй байх.</p>	<p>ХААГ 2015 онд дараах олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ЕСБХБ-тай Ерөнхий гэрээ нэвтрүүлэх чиглэлээр, 2. Азийн хөгжлийн банктай хамтран худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах чиглэлээр, 3. АНУ-ын Азийн сан, Мянганы сорилтын сантай хамтран Олон улсын худалдан авах ажиллагааны мэргэжлийн номын сан байгуулах асуудлаар, 4. Дэлхийн банкнаас санхүүжүүлэх “Ухаалаг засаглал хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх 19,3 сая ам.долларын өртөг бүхий төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тус байгууллагад 2016 онд зохион байгуулахаар болсон. <p>Эдгээр олон улсын байгууллагын санхүүжилт, дэмжлэгтэйгээр 2015 онд албан хаагчдыг гадаадын туршлага судлуулах, мэргэшүүлэх ажлын хүрээнд 5 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөнд давхардсан тоогоор нийт 19 албан хаагчийг хамруулсан. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 14 албан хаагчийг дотоодод худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх сургалтад хамруулсан.</p> <p>Төсвөөс эдгээр чадавхи бэхжүүлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй тул гадаад томилолтын зардлын хэмнэлт гарсан. (Б-100%)</p>	<p>Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
	12 тэмдэглэлийн 16 заалтын дүн:			Хэрэгжилтийн явц – 96,3 хувь: 100%-14, 70%-2.	

ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ДҮН (нэр төрлөөр)
(2015 оны жилийн эцсийн дүнгээр)

№	Холбогдох эрх зүйн акт		Хэрэгжилтийг тооцсон заалт	Хэрэгжилтийн явц (хувь)
	Нэр төрөл	Тоо		
1	УИХ-ын тогтоол	2	2	95,0
2	Ерөнхийлөгчийн зарлиг	-	-	-
3	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	-	-	-
4	Засгийн газрын тогтоол	9	10	86,0
5	Ерөнхий сайдын захирамж	-	-	-
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	12	16	96,3
ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН		23	28	92,5

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ (нийт заалтаар)

Д/д	Хэрэгжилтийн явц (Нийт заалтаар)	Заалтын тоо
1	Нийт хэрэгжүүлэх заалт	28
2	Бүрэн хэрэгжиж биелсэн – (Б.)	21
3	Хэрэгжих шатандаа – (ХШ.)	7
	Үүнээс: 90%	3
	70%	3
	50%	-
	30%	-
	10%	1
4	Хэрэгжүүлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа - (ХБ.)	-
5	Тасарсан – (Т)	-
6	Хэрэгжилтийн хувь	92,5

ХЯНАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ЖАРГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ